

## 4

### ХҮМҮҮН КАПИТАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОНЦЛОГ

---

Д.Хишгээ

#### *Хүмүүн капиталын тухай товчхон өгүүлэх нь*

Танд одоо байгаа бүх зүйлс болох : таны ажил, таны хөрөнгө мөнгө, таны байр, таны эзэмшил газар байхгүй болоод зөвхөн өмссөн хувцастайгаа гудамжинд үлдлээ гэхэд танд ямар нэг “зүйл” үлдэнэ. Тухайлбал: Билл Гейтс ийм байдалд орсон бол яах бол? Тэр яах ч үгүй биздээ. Үнэхээр Майкрософт дампуурч тэрбээр хөрөнгөгүй үлдлээ гэхэд бусад компани түүнийг зөвлөхөөр авна , эсвэл ямар нэг сүлжээний гишүүн болж, эсвэл илтгэл уншиж мөнгө олж дажгүй амьдрах болно. Тэр “зүйл “ бол бодит бөгөөд бидэнд байдаг хүмүүн капитал юм. /1.х60/

Хүмүүн капитал гэдэгт бие хүнд шингэсэн боловсрол, оюун ухаан, уран бүтээлийн авьяас, ажил хийх ур чадвар , аж ахуйч сэтгэлгээний эрч хүч, бүтээлч чадвар, бейсболын бөмбөгийг хүртэл зөв шидэх гэх мэт бүх дадал чадварын нийлбэрийг ойлгодог байна.

Хүмүүн капитал болон биет капитал нь адил тал олонтой. Тухайлбал:

1. Аль аль нь эдийн засгийн нөөцийн зарцуулалтын үр дүнд хуримтлагддаг.
2. Хоёулаа өөр өөр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх бөгөөд удаан хугацааны туршид ашиглагддаг.
3. Амьдралын буюу ашиглалтын хугацааг нь хязгаарлагдмал байдаг.
4. Ашиглагдаж хэрэглэгдсэний үндсэн дээр хоёулаа ашиг оруулж байдаг.

Хүмүүн капитал болоод биет капиталын дээрх адил талууд дээр үндэслэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тодорхой хязгаар дотор адилтгаж үзэх боломжтой. Ингэснээр биет капиталын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны судалгааны аргачлалыг хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын судалгаанд ашиглах боломжийг олгож байна.

**Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэж юуг хэлэх вэ?**

Орчин үеийн эдийн засгийн онолын үүднээс хүний төлөө, түүний хөдөлмөрийн бүтээмж болон орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх зардлыг хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэж үздэг байна. Дээрх зардалд нийгэм, пүүс, хувь хүний зүгээс тухайн хүний эрүүлийг хамгаалах, биеийн тамир спорт, чийрэгжүүлэлт амралт, сургалт боловсрол, боловсон хүчнийг бэлтгэх, дахин сургах, хүүхэд төрүүлэх, өсгөж хүмүүжүүлэх, орон сууцны нөөцийн санг байгуулах зэрэгт зарцуулж байгаа зардлууд орно. Энэ хөрөнгө оруулалт нь бие хүний болон нийгмийн нэг гишүүний хөрөнгө оруулалт учраас маш чухал онцлогтой бөгөөд энэ онцлогыг тухайн өгүүлэлдээ тодорхойлохыг зорилоо.

Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны онцлог нь тухайн капиталын биет капиталаас ялгаатай болохоос урган гарч байна. Эдгээр ялгаатай талуудыг дурдвал:

1. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын өгөөж үр ашиг нь түүнийг тээгч<sup>1</sup> хүний өөрийн амьдралын хугацаанаас шууд хамаарна. Ямар хугацаанд үр ашгаа өгөх нь хөрөнгө оруулалтыг хэзээ эхлэж хийснээс шалтгаална. Хөрөнгө оруулалтыг хичнээн эрт хийх тусам эдийн засаг болон нийгмийн үр ашгаа хурдан өгнө. Хүний амьдрах хугацаа хязгаартайгаас гадна хөдөлмөрийн чадвартай байх хугацаа ч мөн хязгаарлагдмал учраас хүмүүн капиталд хөрөнгө оруулах цаг хугацааг алдвал олох ашгийг алдана гэсэн үг. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын хугацаа 12-20 жил байдаг бол биет капиталын хөрөнгө оруулалтын хугацаа 1-5 жил байдаг.
2. Тухайн хүнд хөрөнгө оруулахын хирээр тодорхой хязгаар хүртэл үр ашиг нь өсөж байснаа гэнэт буурдаг, Хүмүүн капиталын үр ашгаа өгөх дээд хязгаар нь хүний хөдөлмөрийн идэвхитэй насаар тодорхойлогдоно.
3. Аливаа хүний мэдлэг чадвар нөөц боломж хязгаарлагдмал учир нэмэлт мэдлэг мэдээлэл олж авах нь цаг хугацааны явцаас шалтгаалан их хүч чармайлтыг шаарддаг байна.
4. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын эрсдэлийн зэрэг хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхийн хирээр нэмэгдэнэ.
5. Тухайн хүнд оруулсан хөрөнгө оруулалт нийгмийн, оюун санааны болон хууль эрхийн сонирхолыг хангаж байгаа тохиолдолд хүмүүн капиталын хөрөнгө оруулалт болсон гэж тооцдог.
6. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь хэмжээний хувьд их, хугацааны хувьд урт, эдийн засаг- нийгмийн үр ашгийн хувьд нэгдмэл шинж чанартай байдаг.
7. Орчин үеийн аж үйлдвэржсэн нийгмийн хувьд ШУТД-ийн шаардлагыг хангахын тулд хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын чиглэл төрлүүд нь өөрчлөгдөж байна. Түүнчлэн хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын төрөлжилт нь улс орны ёс заншил, үндэсний онцлог, түүхэн хөгжлөөс хамаарч өөр өөр байдаг.
8. Хэрэглээний нийт зардалд хүмүүн капитал ихэвчлэн далд байдаг бөгөөд түүний хуримтлалд зарцуулсан зардал нь хөрөнгө оруулалтын хэлбэрээр илэрнэ. Тээгч<sup>1</sup>- хүн болон хүмүүн капитал хоорондоо салшгүй боловч эдийн засгийн агууллагаараа ялгаатай ойлголт учраас “тээгч” гэсэн үгийг ашиглалаа.

Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухаанд хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын тухайд үзэл баримтлалын хоёр чиглэл оршиж байгаа нь “хувь хүнд оруулсан хөрөнгө оруулалт” ба “хүмүүн капиталын үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалт” болно. Эхний чиглэлийн төлөөлөгч нь Чикаго –гийн сургуулийн төлөөлөгчид болох Л.Туроу, С.Боулс, Ф.Махлуп нар болно. Дээрх эрдэмтэд хүний хөрөнгө оруулалтыг “ахиу ханамж ,ахиу бүтээмж”-ийн онол дээр суурилан тайлбарладаг бөгөөд хөрөнгө оруулалтын үндсэн төрөлд байгалийн баялаг, биет капитал, мөнгөн хэлбэрийн хөрөнгө оруулалт ,хүний амьдрах цаг хугацааг авч үзсэн байна. Нөгөөх чиглэл болох “хүмүүн капиталын үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт”-ын үзэл баримтлалын гол төлөөлөгчид нь Т.Шульц, Г.Беккер, Й.Бен-Порет, Т.Минцер болон бусад эдийн засагчид нь хүмүүн капитал бүрэлдэн тогтох, хуримтлагдахад нөлөөлж байгаа хүний бүх төрлийн үйл хөдлөлийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хамааруулж үзсэн байна. Т.Шульц боловсрол олж авах , үйлдвэрлэл дээр суралцах, эрүүл мэндээ анхаарах, эдийн засгийн мэдээллээр хангах зэрэг хүний үйл ажиллагааг хөрөнгө оруулалтанд хамааруулжээ. Ц.Гриликес мэдлэг дадал чадвар бий болоход хамгийн чухал нь оюутан болон багшийн хөдөлмөрийн үр дүнд хүмүүн капитал үйлдвэрлэгдэнэ гэж тэмдэглэсэн нь сонирхол татаж байна. /2.х76/

Дээрх эдийн засагчдийн үзлээр хүний мэдлэг чадварыг бий болгон хөгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой хөдөлмөрийн зардал шаардагдах нийгмийн зорилго чиглэл бүхий процесс юм. Энэхүү тодорхой хөдөлмөрийн зардлын бүтцийг харуулбал:

- Хүмүүн капитал тээгчийн мэдлэг ,дадлага хуримтлуулах боловсрол олж авах, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан хөдөлмөрийн зардал
- Гэр бүлээс тухайн хувь хүнийг хөдөлмөрийн насанд хүртэл нь өсгөж хүмүүжүүлэхэд зарцуулсан зардал
- Тухайн хувь хүнийг хүрээлэн байгаа орчныг бүрдүүлэхэд зориулсан нийгмийн салбарт ажиллагсадын хөдөлмөрийн зардал. Нийгмийн салбарт эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир спорт зэрэг болно.

К.Макконнелл, С. Брю нар хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын тухайд :

“Ажилчны мэргэжил мэдлэг чадварыг дээшлүүлснээр хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд чигэлсэн бүх зардал, үйл ажиллагааг хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэнэ. Учир нь хэн нэгний хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд гарч байгаа зардал нь ирээдүйд ихээхэн орлого олох зорилгоор зарцуулагдаж байдаг гэжээ” /8.х171/ Энэ тодорхойлолт нь хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын агуулга ба мөн чанарыг товч тодорхой ойлгомжтой гаргажээ.

К.Макконнелл, С.Брю нар хүмүүн капиталын хөрөнгө оруулалтыг дараах байдлаар төрөлжүүлэн тодорхойлжээ.

- Эрүүл мэндийн зардал
- Боловсролын зардал
- Мэргэжил эзэмших зардал
- Ажил эрж хайх, цалин хөлсний тухай мэдээлэл олж авах зардал
- Шилжих, хөдөлгөөнтэй холбогдох зардал
- Үр хүүхдээ төрүүлж өсгөн хүмүүжүүлэхтэй холбогдох зардал

Түүнчлэн дээр дурьдсан зардлууд дээр суурь болон хавсрага шинжлэх ухааны судалгааны зардлыг оруулах нь зүйтэй юм. Учир нь энэ зардал нь хувь хүний мэдлэг чадварыг дээшлүүлэх төдийгүй нийгмийн хөгжилд маш чухал үүрэгтэй билээ. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын дээрхи төрлийг бүлэглэн дараах бүтцэд хамааруулжээ. Үүнд:

1. Боловсрол
2. Эрүүл мэнд
3. Шилжих хөдөлгөөн

Эдгээрийг тус бүрт нь авч үзье.

### ***Боловсрол нь хүмүүн капиталын хөрөнгө оруулалт***

Яагаад Америк орон баян өөрөөр хэлбэл тэнд хүмүүс тансаг сайхан амьдарч байна. Софтварын программчин, мэс засалч, цөмийн инженерүүд, зохиолчид, нягтлан, банкны ажилтан, багш гээд бүгд сайхан хангалуун амьдарч байдаг. Тэдгээрийн зарим нь байгалиас заяасан авьяастай байдаг ч олонх нь боловсрол, тусгай мэргэжил эзэмших сургалтын үр дүнд бий болсон дадлага чадвартай холбоотой байна. Өөрөөр хэлбэл энэхүү тансаг амьдрал нь хүмүүн капиталд хөрөнгө оруулсны үр дүн мөн. Казино тоглож олсон мөнгөөр жижиг үйлдвэрлэл эрхлэх зэрэг бусад салбарт хөрөнгө оруулдагийн адилаар өнөөдөр хүмүүн капиталд хөрөнгө оруулах нь ирээдүйд орлого олох явдал мөн /1.х 65/

Орчин үеийн эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл нь ШУТД учир ажиллах хүчний мөн чанарыг тооны төдийгүй чанарын талаар улам боловсронгуй болгох шаардлагатай болж байна. Ийм учраас боловсролын хөрөнгө оруулалт нь:

1. Хүмүүн капитал тээгч нэг бүрийн ерөнхий боловсрол, хөдөлмөрийн чадвар дадал, бүтээлч үйл ажиллагааг төлөвшүүлэх
2. Нийгмийн гишүүн бүрийн ажиллаж байгаа салбарын онцлогыг агуулсан тусгай мэргэжил, тодорхой мэдлэгийн ур чадварын төлөвшилтийг хангах
3. Зах зээлийн шаардлагын дагуу хөдөлмөрийн бүтээмжийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд мэдлэг чадвар дадлыг байнга нөхөн сэргээхэд чиглэнэ.

Сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй оронд боловсролын салбарын хөрөнгө оруулалт өсөх хандлагатай байна. Тухайлбал: АНУ-д боловсролын салбарын зардал ДНБ-ний 7,5%-ийг эзэлдэг байна. Мөн пүүс, компаниас ажилчдынхаа мэргэжилийн ур чадварыг дээшлүүлэхэд гаргаж байгаа зардал нь ДНБ-ний 3-5% ийг эзэлж байна. Боловсролын хөрөнгө оруулалтын үр ашгийг хоёр талаас авч үзэх нь зүйтэй. Нэг талаас хөрөнгө оруулалтын үндсэн дээр мэргэжил, боловсрол олж авч байгаа субъектийн мэдлэг чадвар, хөдөлмөрийн бүтээмж дээшилснээр цалин хөлс нэмэгдэнэ. Нөгөө талаас боловсролын хөрөнгө оруулалт хийж байгаа субъект болох өрх гэр, пүүсийн ашиг орлого нэмэгдэж амьдралын түвшин, өрсөлдөх чадвар дээшлэнэ.

Үр хүүхдийнхээ хүмүүн капиталд эцэг эхийн оруулсан боловсролын маш сайн чанартай хөрөнгө оруулалт хамгийн чухал байдаг байна. Эцэг эхчүүд хүүхдээ муу хүмүүжүүлэх, тав тухтай боловсролын орчин бий болгоогүйгээс бага сургуулиас эхлэн багш нарын зэмлэл, гомдол тасрахгүй болдог. Г.Беккер тэмдэглэхдээ: Сурч

хүмүүжих явцад сургууль, гэр бүлд бий болсон бага насны хүүхдийн бүр жижиг ялгаа цаг өнгөрөх тусам өссөөр шилжилтийн насанд хүрэхийн үед маш том ангал бий болгодог. Хөдөлмөрийн зах зээл дээр уншиж, бичиж сураагүй, ажил хийх дадал чадвар хөгжөөгүй бол сайн ажил олохгүйд хүрнэ. /1.х68/

**Эрүүл мэндийн хөрөнгө оруулалт нь хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын салшгүй хэсэг мөн.**

Хүмүүн капиталын асуудлыг судлан “Нобелын” шагнал хүртсэн эдийн засагч Г.Беккер боловсрол, мэргэжлийн сургалт, эзэмшсэн дадал чадвар, хүн ардын эрүүл мэнд зэрэг нь орчин үеийн эдийн засгийн нийт баялгийн ихэнх хувийг бүрдүүлнэ гэжээ. Бидний эргэн тойрны амьдралын зайлшгүй эд хогшил, үнэт эдлэл, байшин барилга, газрын тос ч ийм баялагийг бүтээж чадахгүй. Тиймээс эдийн засгийг хүмүүн капиталын эдийн засаг ч гэж нэрлэж болох юм. /1.х 78/

Шинжлэх техникийн дэвшлийн үр дүнд орчин үед эрүүл мэндийн салбарын нийгэм эдийн засгийн ач холбогдол улам өсөж байна. Үүнтэй холбоотойгоор эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт ч чанарын хувьд өөрчлөгдөж байна. Хүмүүн капиталын өндөр өгөөж өгөх хугацаа нь 25-45 нас юм. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын гол зорилго нь насны энэ хугацаар уртасгах явдал юм. Хүний эрүүл мэнд нь хөрөнгө оруулалт хийсний үр дүнд үр ашгаа тодорхой өгч байгаа учраас эрүүл мэндийн капитал гэж болно. Энэхүү эрүүл мэндийн капиталыг “удамшсан” болон “хөрөнгө оруулалтын үр дүнд” бий болсон гэж ангилна. Эрүүл мэндийн капитал ашиглагдах хугацаандаа аажмаар элэгдэлд орох бөгөөд нас ахихын хирээр хурдан элэгдэнэ. Эцэст нь нас барах нь эрүүл мэндийн капитал “үнэгүй”-дсэнийг харуулна. Харин эрүүл мэндийн хөрөнгө оруулалт нь энэ процессийг удаашруулна. Барууны эдийн засагчид хөрөнгө оруулалтын үр дүнд бий болж байгаа эрүүл мэндийн капитал нь эцэстээ ямагт орлого оруулдаг учраас хүмүүн капиталын хамгийн гол хэсэг гэж үздэг. Эрүүл мэндийн капиталын хөрөнгө оруулалтын үр дүнд хөдөлмөрийн чадвар алдсаны улмаас алдагдах цаг хугацаа багасаж, энэ хугацаа шинээр бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох шинэ нөөцийг бүрдүүлэхэд зарцуулагдах болно. Эрүүл мэндийн хөрөнгө оруулалт нь:

1. Ажиллах хүчний эргэлтийн хугацааг хурдасгах, ажиллах хугацааг уртасгах, биет элэгдлийн хугацааг удаашруулах
2. Ажилчны бие махбодийн сэтгэл зүйн чадвахийг дээшлүүлэх замаар хүмүүн капиталын өгөөжийг нэмэгдүүлэх
3. Хойч үеийн эрүүл мэндэд нөлөөлөх замаар хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийг хангах зэрэг зорилтуудын шийдвэрлэдэг байна.

Өнөөгийн байдлаар эрүүл мэндийн капиталын хөрөнгө оруулалтын үр ашигтай хэлбэр нь эрүүл мэндийн даатгал хийх явдал юм. Дэлхийн практикт Англи, Дани, Итали, Ирланд, Швед, Финлянд зэрэг орнуудад эрүүл мэндийн даатгалын сангийн ихэнх хэсгийг төрөөс бүрдүүлдэг. Харин Бельги, Герман, Франц, Нидерланд зэрэг орнуудад эрүүл мэндийн даатгалын сангийн ихэнх хэсгийг ажил олгогчоос бүрдүүлдэг байна. Улс оронд эрүүл мэндийн даатгалын санг төрөөс хянаж байдгийн зэрэгцээ улсын төсвийн тодорхой хэсгийг бүрдүүлж байдаг. 2003 оны

байдлаар АНУ-д эрүүл мэндийн капиталын хөрөнгө оруулалт нь ДНБ-ний 13-15%-ийг эзэлж байна. /7.х27/ 2007 оны байдлаар Монголд энэ үзүүлэлт 7,3% тай байна.

***Шилжих хөдөлгөөний хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын тухай.***

Хүмүүн капиталын шилжих хөдөлгөөн нь илүү бүтээмжтэй, илүү цалинтай, таатай газар оронд шилжин ажиллах хүсэл эрмэлзэлтэй холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл хүмүүн капиталыг дахин хуваарилах, хүний нөөцийг өндөр бүтээмжтэй, илүү цалинтай салбар, газар орнуудад зөв хуваарилахтай холбогдон гарах зардал юм. Энд зөвхөн өндөр цалин хөлсний тухай төдийгүй Л.Туроугийн “ахиу ханамжийн” онолоос үндэслэн цаг агаар, экологийн нөхцлийг багтаасан шинэ ажлын байрны таатай орчныг бий болгоход чиглэсэн бүх зардлыг хамааруулж авч үздэг байна. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөнтэй холбоотой гарч байгаа зардал шинэ нөхцөлд ажилчныг бэлтгэх, түүний чадварыг сайжруулахад зарцуулагдах бөгөөд ажилгүйдлийн түвшинг бууруулах ач холбогдолтой. Зах зээлийн нөхцөл байдалд ажиллах хүчний дасан зохицох чадвараар шилжилт хөдөлгөөний мөн чанарыг тодорхойлж болно. Энэ үйл ажиллагаа дараах хоёр зорилгыг агуулна.

1. Хүмүүн капиталыг шинэ нөхцөлд ашиглан цалин хөлсөө өндрөөр үнэлүүлэх
2. Хөдөлмөрийн зах зээл дээр шудрага ёс, тэгш эрхийг баталгаажуулах

***Хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт***

Хүүхэд төрүүлж өсгөх, хүмүүжүүлэхтэй холбоотой гарч байгаа зардал нь хүмүүн капитал тээгчийн нөхөн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт юм. Хүүхдийг төрөхөөс эхлэн насанд хүрэх хүртэл гарч байгаа зардал нь эцэг эхээс хүүхдэд удаан хугацааны туршид оруулж буй хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт болно. Энэ хөрөнгө оруулалт нь эцэг эхэд үр хүүхдээ сайн сайхан өсгөж бойжуулсан сэтгэл санааны болон бэлэн мөнгөний хэлбэрээр өгөөжөө өгч байдаг. Нөгөө талаас үр хүүхдийн өөрт нь хуримтлах хүмүүн капиталын хэлбэрээр үр ашгаа өгнө. Хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийн процесс нь үндсэндээ гэр бүлийн хүрээнд буюу микро эдийн засгийн түвшинд байдаг онцлогтой бөгөөд нөхөн үржих болон нийгмийн зардал гаргахыг шаардаж байдаг. Нийгмийн зардалд эцэг эхийн зүгээс хүүхдийн хоол хүнс, хувцас, орон байр, эрүүл мэндэд зарцуулж байгаа мөнгөн хэлбэрийн зардал орно. Макро эдийн засгийн түвшинд дээрх зардлын зэрэгцээ төрөөс хүүхдийн тэтгэмж, цэцэрлэг, сургууль, соёл урлагийн төвийг барьж байгуулахад гарах зардлууд нэмэгдэж байдгийг дурдах нь зүйтэй. Аливаа хүнд оруулж байгаа хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын бүх төрлүүдийг багтаасан хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийн “үнэ цэнэ”-ийг дараах томъёогоор илэрхийлж болох юм.

$$C = (P + E) * \lambda + \Delta_{Y0} + M + m$$

C- хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийн нийт зардал

P- физиологийн зардал / хоол хүнс, хувцас, орон байр, эрүүл мэндийн зардал/

E-нийгмийн зардал / боловсрол, соёл урлаг, спортын зардал

$\Delta_{Y0}$  - эцэг эхийн алдагдсан боломжийн өртөг буюу үйлдвэрлэгдээгүй Y0-н хэмжээ

$\lambda$  – нийгмийн бүлгийн ялгааг тооцох коэффициент

М- нас баралтын үнэлэмж / нярай, хүүхэд, насанд хүрэгч/  
т- шилжих хөдөлгөөнтэй холбоотой зардлууд

### **Шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт**

Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын бүтцийн дараагын хэлбэр нь шинжлэх ухааны салбарт оруулж байга хөрөнгө оруулалт юм. Шинжлэх ухааны салбарын хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь хоёр талын ач холбогдолтой.

Нэг талаас хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон шинжлэх ухааны ололт, нээлтүүд нь шинэ мэдлэг, мэдээллийг өгнө.

Нөгөө талаас шинэ мэдлэгийн үр дүнд боловсрол, эрүүл мэндийн болон бүх салбарын бүтээмж дээшилнэ.

Шинжлэх ухааны судалгааны ажил ба боловсролын процесс нь хоорондоо салшгүй холбоотой, тасралтгүй үйл явц юм. Шинэ мэдлэг олж авах процесс гүнзгийрч, чанарын хувьд сайжирснаар шинжлэх ухааны нээлтүүд гарна. Шинэ нээлтүүд нь хувь хүний төдийгүй нийгмийн бүтээмжийг дээшлүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл юм. Нийгмийн бүтээмж дээшлэх нь ийм хэлбэрийн хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үр дүн мөн.

Суурь болон хавсрага шинжлэх ухааны хөрөнгө оруулалт нь:

1. Оюуны капиталыг борлуулах
2. Шинэ мэдлэг хуримтлуулсаны үндсэн дээр төвлөрсөн хүмүүн капиталыг дараагийн шинэ нээлтэнд ашиглах
3. Шинэ мэдлэгийг зорилго чиглэлтэйгээр ашиглан хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зэрэг нөхцлүүдийг хангахад чиглэгдэнэ.

Аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй улс орнууд шинжлэх ухааны хөрөнгө оруулалтанд дунджаар ДНБ –нийхээ 2-3%-ийг зарцуулж байна.

Микро ба макро эдийн засгийн түвшинд зах зээлийн субъектүүд хүмүүн капиталын хөрөнгө оруулалтыг дараах байдлаар хийнэ. Үүнд:

Нэгдүгээрт, Гэрийн аж ахуй үр хүүхдээ төрүүлж, бойжуулж, хүмүүжүүлж, боловсрол олгоход тодорхой хөрөнгө зарцуулна. Өөрөөр хэлбэл хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийнэ.

Хоёрдугаарт, Ашиг олох, өрсөлдөх чадвараа сайжруулах зорилгоор үйлдвэрийн газрууд хүмүүн капиталын хөрөнгө оруулалт хийнэ.

Эдгээр нь микро эдийн засгийн түвшний хөрөнгө оруулалт юм.

Гуравдугаарт, Төрөөс нийт нийгмийн хүмүүн капиталыг хадгалах, аривжуулах зорилгоор хөрөнгө оруулалт хийнэ. Энэ нь макро эдийн засгийн түвшний хөрөнгө оруулалт юм. Эдгээрээс гадна салбарын түвшинд ч хүмүүн капиталын хөрөнгө оруулалт хийгддэг.

Хүмүүн капитал бүрэлдэн бий болж хуримтлагдахад төрийн үүрэг өссөөр байна. Микро эдийн засгийн түвшинд хийгдэж байга хөрөнгө оруулалт нь шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байгаа учраас төрөөс нэмэлт хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй болж байна.

Сүүлийн жилүүдэд ялангуяа өндөр хөгжилтэй улс орнууд хүмүүн капиталын өсөлтөнд онцгой анхаарал тавьж түүний хөрөнгө оруулалтанд их хэмжээний хөрөнгө зарцуулах болсон байна. Үүнийг дараах тоо баримтуудаас харж болно.

Тухайлбал: ХБНГУ-д ихэнх их дэд сургуулийн санхүүжилтийг төрөөс хариуцдаг. АНУ-д их дээд сургуулийн санхүүжилтийн 60%-ийг төрөөс хариуцдаг байна. Мөн АНУ-д эриил мэндийн салбарын хөрөнгө оруулатын 44%-ийг төрөөс санхүүжүүлж байна. (б.х.78-83х)

Шилжих хөдөлгөөнтэй холбоотой зардалд ажлийн шинэ байр бий болгох, ажлах хүчийг шинээр бэлтгэх дахин бэлтгэхтэй холбоотой зардлууд, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг орно. Ихэнх улс орнууд энэ төрлийн зардалд дунджаар ДНБ-нийхээ 2-3%-ийг зарцуулж байна.

Шинэ мэдлэгийн үйлдвэрлэл буюу шинжлэх ухааны судалгааны зардлын ихэнх хувийг төрөөс санхүүжүүлдэг.

Оюуны капиталын санхүүжилтэнд төрийн эзлэх хувийн жин АНУ-д 47,1%, Японд 19,6%, ХБНГУ-д 37,1%, Франц-д 45,7%, Англи-д 52,1%, Итали-д 49,9%, Канад-д 42,6% байна. (б.х.78-83х)

Төрөөс урлаг, соёл, биеийн тамир спорт гэх мэт дэд бүтцийн салбарт их хэмжээний хөрөнгө зарцуулдаг. Гэхдээ энэ зардалын улсын төсөвт эзлэх хувийн жин нь боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарт зориулж байгаа зардлаас харицангүй бага байдаг. Ингэх хөгжингүй орнууд төсвийн зардлынхаа 1,5-2,5%-ийг энэ дэд бүтцийн салбарт зарцуулж байна.

Пүүс компаниуд тогтмол ашигтай ажиллах, өрсөлдөх чадвараа сайжруулах зорилгоор хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийж байна. Пүүс компаниудын хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын хэмжээ нийт хөрөнгө оруулалтын нилээд хувийг эзэлдэг. Микро түвшний ийм хөрөнгө оруулалт нь илүү үр ашигтай. Учир нь Пүүс компаниуд нь зах зээлийн шаардлага, өөрчлөлтийг хурдан тусгаж хөрөнгө оруулалтын чиглэлээ өөрчлөл чадвартай.

Пүүс компаниудаас хийж байгаа хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь дараах онцлогтой:

1. Үйлдвэрийн газрууд нь зөвхөн өөрийн үйлдвэрлэлийн онцлогт тохирсон мэдлэг, дадлага, туршлагыг бий болгоход л хөрөнгө иоруулалт хийх бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын эрсдлийг бууруулна.
2. Үйлдвэрийг газрууд нь цэвэр орлого авчирч байгаа тохиолдолд л хүмүүн капиталд хөрөнгө оруулалт хийнэ.

Хэдийгээр төрөөс, үйлдвэрийн газруудаас, гэр бүлээс хөрөнгө оруулах боловч энэ капиталын хуримтлал нь түүнийг тээгч хувь хүний сонирхол, зорилго, хүсэл эрмэлзлэл, хүч чармайлтаас ихээхэн шалтгаална. Өрх гэрийн түвшинд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын талаар нарийн тоо баримт дурьдах болмжгүй. Энд зөвхөн хувь хүний өөрийнх нь хүсэл сонирхол дээр үндэслэн өрх гэрийн хөрөнгө оруулалт хийгдэнэ гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Эцэст нь хүмүүн капитал нь хүнээс өөрөөс нь салшгүй бөгөөд түүнийг барьцаанд тавьж болохгүй, арилжигдаж худалдагдахгүй. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын процесс нь биет капиталын хөрөнгө оруулалттай харьцуулахад урт бөгөөд түүнд оруулсан хөрөнгө оруулалтын эрсдлийг даатгуулах боломжгүй.

Хүмүүн капиталын үйлдвэрлэл гэдэг нь нийгмийн үйлдвэрлэл – нөхөн үйлдвэрлэлийн процесс-д ашиглагдах, бүтээх чадварыг бий болгож, хуримтлуулна.



гэсэн ойлголт юм. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт нь түүний мөн чанарын онцлогоос хамаарна. Хүмүүн капиталд зарцуулагдаж байгаа бүх хөрөнгө нь эдийн засгийн алдагдал биш харин ашиг авчирдаг бодит хөрөнгө оруулалт юм. Хүмүүн капиталыг бүрэлдэн бий болох, хуритлагдахад зарцуулагдаж байгаа хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийн төдийгүй нийгмийн, үзэл сурталын, соёлын ач холбогдолтой.

*Ашигласан ном зүй.*

1. Naked economics Undressing the dismah science. Charles Wheehan.2002
2. Богачева О.Государственное финансирование сферы культуры и искусства.
3. (Опыт индустриально-развитых стран) Вопрос экономики.2004.№10с 64-77
4. Гойло В.С Современные теорий воспроизводство рабочей силы. М.Наука. 2000.231с
5. Грейсон Д, Оделли, К.Амерканский менежмент на пороге XXI века М.Экономика. 2001. 319с
6. Дынкин А.А.Иваноа .Н.И. Наука и научная политика\|. Общество и экономика. 2000.№6.С.3-46
7. Иванова.Н. Финансовыемеханизмы научно-технической политика (опыт стран запада ) \|\ Проблемы теорий и практики 2002,№5 с 78-83
8. Козлов .О.А Оценка человеческово капитала в технологим управления современным предприятием\| консультант директора №20 1999. с 27-33
9. Такконнелл К.Р, Брю С.Л экономикс-М: республика. 1993.т-2.400с Мурая.Л. финансирование высшего образования в зарубежных странах\| Экономика сельскохозяйственного производство в России. 2004 №3 с 27.